



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2013 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Зам, тээврийн салбарын стандартыг шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зам, тээврийн салбарын стандартыг шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр /2013-2016/-ийг 1 дүгээр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Р.Онон, Д.Батбаатар, Ё.Манлайбаяр, Б.Очирсүх/ нарт үүрэг болгосугай.


3. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг яамны зохион байгуулалтын дотоод бүтцийн нэгжийн дарга нарт, хөтөлбөрийн явц, хэрэгжилтэд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэдээлж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Махбал/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/-д даалгасугай.



А.ГАНСҮХ

Зам, тээврийн сайдын 2013 оны
0.4 дугаар сарын 25 өдрийн 85 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН СТАНДАРТЧИЛЛЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР /2013-2016 ОН/

НЭГ. ОРШИЛ

Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/ нь манай улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг эрчимтэй хөгжүүлэх замаар Монгол Улсын зам, тээврийн салбарыг хөгжингүй орны жишигт хүргэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөрийн зорилт нь эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцлийг хангахуйц, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, цаашдын хөгжлийн үндэс болох стандарт, техникийн баримт бичгийн тогтолцооны суурь нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Хөтөлбөр нь Зам, тээврийн салбарт шинэ дэвшилтэт технологи тусгасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, стандартуудыг үндэсний стандарт болгон нэвтрүүлэх, одоогийн хэрэглэгдэж буй стандартуудыг шинэчлэн сайжруулах, шинэчлэн боловсруулахад шаардагдах санхүүжилтийн эх үүвэр болон хүрэх үр дүнг тодорхойлсон.

ХОЁР. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАНДАРТЧИЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зах зээлийн харилцааны нөхцөлд хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүйгээр өөрөөр хэлбэл стандарт хэрэглэхгүйгээр ямар ч үйлдвэрлэл эрхлэх боломжгүй. Энэ бол эдийн засгийн харилцаанд чанд мөрддөг нэг ёсны хууль юм.


2.1. Авто замын салбарын стандарт

Авто замын салбар нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад хандивлагч байгууллагуудын шугамаар хэрэгжиж байгаа төслүүдээр дамжуулан АНУ-ын AASHTO, ASTM-ын байгууллагын зөвхөн материал шинжилгээ, туршилт судалгааны багахан хэмжээний стандартуудыг эх хэлнээ хөрвүүлэн боловсруулж, 150 гаруй стандарт мөрдөж байгаа ч замын зураг төсөл, төлөвлөлт, гүүр, хиймэл байгууламж, замын засвар арчлалтын чиглэлийн стандартын нэгжгүй байна.

2.2. Авто тээврийн салбарын стандарт

Авто тээврийн салбарт 66 стандарт мөрдөгдөж байгаагаас заавал мөрдөх стандарт 45 буюу 68 хувь, сонгон хэрэглэх стандарт 21 буюу 32 хувь байна.

Тус салбарт мөрдөж буй нийт стандартын төрлөөр нь үзвэл 48 нь бүтээгдэхүүний, 8 нь турших аргын стандарт, 10 нь нэр томъёоны стандарт



138

байгаагаас ISO стандартын 20 стандарт буюу 30,3 хувь, гадаад орны 26 стандарт буюу 39,3 хувь, үндэсний 20 стандарт буюу 30,3 хувь байна.

2.3. Төмөр замын салбарын стандарт

Төмөр замын салбарт нийт 23 нь үндэсний стандарт мөрдөгдөж байгаа ба тэдгээр нь Олон улсын болон бүс нутгийн стандартыг нутагшуулсан болно.

Төмөр замын салбарт сүүлийн жилүүдэд олон улсын 10 гаруй стандартыг батлуулан мөрдөж байна.

Зайлшгүй шаардлагатай стандарт, техникийн баримт бичгүүдийг боловсруулах ажил удааширч, төмөр замын суурь бүтцийн барилгын зураг төслийн болон барилга угсралт, засварын ажилд ихээхэн бэрхшээл үүсч байна.

2.4. Далай ашиглалт, усан замын салбарын стандарт

Өнөөдрийн байдлаар Монгол улсын далайн тээврийн салбар нь олон улсын гэрээ, конвенци болон тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулсан протоколууд зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагдаж байна.

Усан замын тээврийн салбарт усан замын тээврийн хөдөлгөөний удирдлага, жолоодлого /навигаци/-д хэрэглэх дохио, тэмдэг суурилуулах ба байршуулах төрөл загвар, нэр томъёо, тодорхойлолт гэсэн MNS стандартын зөвхөн нэг нэгжтэй болоод байна.


2.5. Иргэний нисэхийн салбарын стандарт

Монгол Улс 1989 онд Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцид нэгдэн, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн Иргэний нисэхийн ерөнхий газрыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулсан.

Иргэний нисэх нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Шинэ Зеланд, АНУ зэрэг орны иргэний нисэхийн дүрмийг суурь болгон боловсруулсан техникийн баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Мөн 1989 онд баталсан аэродромын барилга угсралтын норм, аэродромын төсвийн жишиг норм, 2008 онд үндэсний стандартаар батлуулсан газрын тосны бүтээгдэхүүний сорилт, шинжилгээний 9 MNS стандартаас өөр стандарт баримт бичиг байхгүй байна.

Иргэний нисэхийн салбарт хэрэглэх нэр томъёо, хэмжил зүй, оношлогоо, сорилт шинжилгээ, аэродром, барилга байгууламж, үйл ажиллагаа, үйлчилгээний стандарт, техникийн шаардлагуудыг боловсруулан, үндэсний стандарт болгон батлуулан мөрдөх шаардлагатай байна.



ГУРАВ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

3.1. Олон улсын стандартчиллын хөгжлийн чиг хандлага

Олон улсын стандартчиллын тогтолцоо хөгжөөд 150 орчим жил болж байгаа бөгөөд олон улсад стандартыг чөлөөт худалдаа ба шударга үнэнийг дэмждэг гэж үздэг.

Олон улсын стандартын байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагаас “Нэг стандарт-нэг тохирлын үнэлгээ-нэг итгэмжлэл” уриаг дэвшүүлж, дэлхий нийтээрээ даяаршиж буй энэ үед стандартын цаашдын чиг хандлага тодорхой бас нэг зүгт байвал олон зүйлийг хамтдаа бүтээн өөрчилж чадна гэж тодорхойлсон.

Зүүн Европ, Балтийн орнууд шилжилтийн үеэсээ маш хурдацтай гарч, хөгжлийн зам руугаа орж байна. Тэд ийм хурдтай нийгэмшиж, иргэншиж, хөгжиж байгаа нь эдгээр орнуудад хийгдсэн стандартын шинэчлэл хамгийн чухал нөлөө үзүүлсэн гэж үздэг байна.

Стандарт нь хөгжингүй орноос хөгжиж буй оронд технологи дамжуулах замаар үйлдвэрлэлийг дэмжих хэрэгсэл болдог.

3.2. Монгол Улсын стандартчиллын чиг хандлага

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 6200 гаруй үндэсний стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд эдгээр стандартын 45 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны стандарттай нийцсэн байна.

Үндэсний стандартын 23 хувь нь 1990 оноос өмнө, 18 хувь нь 1991-2000 оны хооронд, 59 хувь нь 2001 оноос хойш тус тус батлагдсан стандартууд мөрдөгдөж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих үе хүртэл ОХУ-ын “ГОСТ”-ыг шууд эх хэлнээ хөрвүүлэн батлуулж, хэрэглэж ирсэн ба 1990-ээд оноос хойш гадаад хамтын ажиллагаа өргөжин, олон улсын хандивлагч байгууллагуудын хөрөнгө оруулалттай төслүүд хэрэгжиж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр хөгжилтэй орнуудын стандарт, техникийн баримт бичгийг ашиглах болсон.

Үндэсний стандартыг олон улс, бүс нутаг, эдийн засгийн өндөр хөгжилтэй орны стандартчилал, тохирлын үнэлгээний талаар гаргасан зарчим, стандарт, баримт бичгүүдэд нийцүүлэн стандартын шинжлэх ухаан техникийн түвшинг дээшлүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын стандарчилал нь бүтээгдхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны саад хотгорыг бууруулах зорилгоор үндэсний стандартыг олон улсын стандартын нийтлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэхэд чиглэж байна.

3.3. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Манай улс стандартчиллын байдалдаа үнэлгээ өгч, бодлогоо тодорхойлоогүйгээс нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт технологийн түвшин дэлхийн жишгээс хоцронгуй байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор зам, тээврийн салбарт нэвтрүүлэх технологийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, бүтээгдэхүүн,

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

Сайд, Ториин нэрийн бичгийн даргын
2015 оны 05 дугаар тушаал

үйлчилгээнд нэвтрүүлэх технолгои, стандартчиллын тогтолцоог бүрдүүлэх шаардлага гарч байна.

Зам, тээврийн салбарт дэвшилтэт стандартчиллыг нэвтрүүлж, боловсронгуй болгосоноор төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагууд гэх мэт, захиалагч, гүйцэтгэгч, оролцогч талуудын уялдаа холбоог нягтруулж үйл ажиллагааны хамгийн наад захын шаардлагыг ижилсгэх юм.

Зам, тээврийн салбарын үйл ажиллагааны хүрээнд олон улсын шаардлагыг хангах стандартуудыг боловсруулан мөрдөж, нутагшуулан хөгжүүлсэнээр эдийн засгийн өсөлтийг ханган, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Салбарын стандартыг боловсронгуй болгосоноор судалгаа шинжилгээ, боловсон хүчний чадавхийг үр ашигтай хослуулан хөгжүүлж, ачаа болон зорчигч тээвэрлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэгдсэн нэгдсэн тээврийн системийн бодлого, зохицуулалт, техникийн баримт бичгийн тогтолцоог бий болгох юм.

Хөгжиж байгаа болон шилжилтийн эдийн засагтай орнуудын туршлагаас үзэхэд суурь судалгаанд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулах замаар шинэ технолгои, стандартыг бий болгох нь өрөөсгөл бөгөөд хүндрэлтэй гэдэг нь нэгэнт илэрхий болж, аль болох өнөөгийн нөхцөл байдал, эдийн засгийн нөөц боломжиндоо тулгуурлан нэгэнт бий болсон гадаадын дэвшилтэт техник технолгои, стандартыг нутагшуулах замаар улс орноо хөгжүүлэх нь цаг хугацааны хувьд үр ашигтай юм.

Нөгөө талаар даяаршлын эрин үед улс орнуудын хооронд мэдлэг, мэдээлэл солилцох, олж авах боломж нээлттэй болж, аливаа улс орны чадавхи тухайн орны шинжлэх ухаан технологийн хөгжлөөс гадна дэлхий нийтийн хандлага, хууль эрх зүйн орчны боловсронгуй байдал, техникийн салбарт мөрдөж буй стандарт, баримт бичгийн түвшнээс ихээхэн хамаарах болжээ.

УИХ –ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” –ын “Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд:

- Авто замын барилга угсралт, засвар, арчлалтын норм болон дүрэм, стандартыг боловсронгуй болгох;
- Авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, усан замын тээврийн тухай хуулиуд, холбогдох стандартууд, дүрэм журмуудад өөрчлөлт оруулахын зэрэгцээ зарим хуулийг шинээр баталж мөрдүүлэх;
- Олон улсын конвенц, стандарт, шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох гэж тодорхойлсон.

УИХ –ын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр” –ийн “Аюулгүй орчинтой Монгол хүн” зорилтын хүрээнд Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол улсад нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлэхээр тусгагдсан.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

Сайд, Төрийн үндэсний бичгийн даргын
2013 оны 85 дугаар тушаал

Дээрх зорилтын хүрээнд зам, тээврийн салбарт шинэ дэвшилтэт үр дүнг тусгасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, стандартуудыг нэвтрүүлэн салбарын стандартчиллыг боловсронгуй болгох бодлого хэрэгжүүлэх нь чухал юм.

Зам, тээврийн салбарын стандартууд нь шинжлэх ухаан техникийн түвшингийн улсын үзлэгээр Зам, тээврийн салбарт хүчин төгөлдөр 247 стандарт мөрдөгдөж байна.

Үндэсний стандартын төрлөөр ангилахад бүтээгдэхүүний 116, шинжилгээний арга, аргачлалын 108, нэр томъёоны 15, бусад 8 стандарт байна. Үзлэгийн хүрээнд үндэсний стандартыг дахин хянахад хүчингүй болгох 2, дахин хянах 123, хэвээр мөрдөх 115, шууд олон улсын стандартаар орлуулах 7 стандарт байгаа нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Транзит Монгол" үндэсний хөтөлбөр, "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгасан стандартчиллын тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, салбарт мөрдөж буй стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох шаардлагатай уялдуулан стандартчиллын шинэчлэлийг удирдлага, зохион байгуулалтаар хангах асуудлыг цогцоор шийдвэрлэх зорилгоор "Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсрууллаа.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ


4.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь Монгол Улсын Зам, тээврийн салбарын онцлогт тохирсон, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц таатай орчинг бүрдүүлсэн нэгдсэн тээврийн үйлчилгээний хөгжлийг хангахуйц, эрэлт хэрэгцээнд нийцсэн, цаашдын хөгжлийн үндэс болох стандарт, техникийн баримт бичгийн тогтолцоог хөгжүүлэх суурь нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Энэхүү зорилгыг дараах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн зорилт

4.2.1. Нэг дүгээр зорилт: Олон улсын болон бүс нутгийн стандартыг Монголд нутагшуулах

Энэхүү зорилтын хүрээнд Олон улсын стандартчиллын байгууллага/ISO/, Европын стандартын нийгэмлэг/CEN/, Германы стандартын институт/DIN/, Америкийн стандартын Стандартчиллын институт /ANSI/, /ASTM/, /AASHTO/ Канадын /CSA/ зэрэг байгууллагуудаас гаргаж буй стандартуудаас Монгол Улсын байгаль цаг уур, улс орны онцлогт нийцсэн дэвшилтэд стандартыг нэвтрүүлэхэд чиглэгдэнэ.



4.2.2. Хоёр дугаар зорилт: Үндэсний стандартуудыг шинэчлэн боловсруулах

Энэхүү зорилтын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй олон улсын болон үндэсний стандартуудыг дахин хянах, шинэчлэх,

Зам, тээврийн салбарт нэвтрүүлэх шинэ дэвшилтэт стандартуудыг мөрдүүлж аюулгүй, ая тухтай, хүртээмжтэй, чанартай зам, тээврийн үйлчилгээг бий болгох арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ.

4.2.3. Гурав дугаар зорилт: Сургалт, сурталчилгаа, хэрэгжилтийг зохион байгуулах

Энэхүү зорилтын хүрээнд стандарт, баримт бичгүүдийг боловсруулах зам тээврийн салбарын стандартчиллыг шинэчлэхэд ур чадвартай боловсон хүчинг дээд боловсролын түвшинд бэлтгэх хүний нөөцийг бүрдүүлэх, стандартыг хэрэглэгчдэд таниулан сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулахад чиглэгдэнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Хөтөлбөрт Монгол орны байгаль цаг уурын эрс тэс онцлог, эдийн засгийн нөхцлийг харгалзан үзэж стандартын түвшинг үнэлэх, тогтолцоог хөгжүүлэх үзэл баримтлал, стратегийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилттой уялдуулан тодорхойлсон болно.

Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө, Монголд нутагшуулах болон шинэчлэн боловсруулах стандартын жагсаалт гарган боловсруулаж мөрдөнө.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх ажлыг зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

6.1. Хамрах хүрээ

6.1.1. Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрт авто зам, авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, усан замын тээврийн салбарт мөрдөгдөх стандартуудыг шинэчлэн боловсруулах, олон улсын болон бүс нутгийн дэвшилтэт стандартуудыг Монголд нутагшуулах үйл ажиллагаа хамаарна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Салд. Төрийн өөрийн бичгийн даргаар
2013 оны 85 дугаар тушаал

142

6.1.2. Зам, тээврийн салбарт олон улсын жишигт дэвшилтэт стандартуудыг худалдан авч, боловсруулж, батлуулах ажилд дараах төрийн болох төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгж хамрагдана.

6.2. Байгууллагуудын оролцоо

6.2.1. Төрийн байгууллагууд

Зам, тээвэр, гадаад хэрэг, санхүү, уул уурхай, байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын асуудал хариусан төрийн захиргааны төв байгууллага зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, улсын төсөвт үйлдвэрийн газрууд, нийслэлийн төр захиргааны байгууллагууд, их дээд сургуулиуд; салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, лабораториуд.

6.2.2. Төрийн бус байгууллагууд

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын авто замчдын холбоо, Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо, Монголын авто инженерүүдийн холбоо, Монголын тээвэр зуучдын холбоод, логистикийн төвүүд зэрэг холбогдох бусад төрийн бус байгууллагууд.

6.2.3. Аж ахуйн нэгж байгууллагууд


Зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л хувийн хэвшил, аж ахуйн нэгж болох тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагууд, экспорт импорт, дамжин өнгөрөх худалдаа, тээвэр, тээвэр зуучлал, лабораторийн шинжилгээ зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг холбогдох хувийн хэвшил аж ахуйн нэгж.

6.3. Олон улсын болон бүс нутгийн стандартыг Монголд нутагшуулах

6.3.1. шинээр нэвтрүүлэх стандартын тогтолцооны талаар судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын стандартчиллын төлөвлөгөө гаргах;

6.3.2. салбарын стандартыг боловсронгуй болгох чиглэлээр гадаад орны тэргүүн туршлага судлан, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол орны нөхцөлд хэрэглэхэд тохиромжтой стандартуудыг сонгон хамтран ажиллах талаар гэрээ хэлэлцээр байгуулах ажлуудыг зохион байгуулах;

6.3.3. Олон улсын стандартчиллын байгууллага /ISO/, Европын стандартын нийгэмлэг /CEN/, Германы стандартын институт /DIN/, Америкийн стандартын байгууллага /AASHTO/, /ASTM/ Канадын /CSA/ зэрэг байгууллагуудаас гаргаж буй стандартуудаас зам тээврийн салбарт хамаарал бүхий стандартуудын талаар судалгаа хийн Монгол Улсын зам тээврийн салбарт мөрдөх шаардлагатай стандартуудыг сонгон авч хэрэгжүүлэх ажлыг хийх хугацаатай тодорхой заасан төлөвлөгөө гаргах;



6.3.4. ISO-ийн стандарт, Европын холбоо, бусад дэвшилтэт нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол улсын зам, тээврийн салбарт үе шаттай нэвтрүүлэн, мөрдүүлэх;

6.3.5. зам, тээврийн салбарт нэвтрүүлэх шинэ дэвшилтэт стандартуудыг мөрдүүлж аюулгүй, ая тухтай, хүртээмжтэй, чанартай зам, тээврийн үйлчилгээг бий болгох арга хэмжээг зохион байгуулах;

6.3.6. салбарын стандартчиллын техникийн хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэх;

6.4. Үндэсний стандартуудыг шинэчлэн боловсруулах

6.4.1. Монгол Улсын зам, тээврийн салбарт мөрдөж буй олон улсын болон үндэсний нийт стандартуудад шинжлэх ухаан, техникийн үзлэг хийж дүгнэлт гаргах;

6.4.2. үзлэгийн дүгнэлтийг үндэслэн цаашид мөрдөх шаардлагагүй стандартуудыг хүчингүй болгох;

6.4.3. үзлэгийн дүгнэлтийг үндэслэн цаашид үргэлжлүүлэн мөрдөх шаардлагтай үндэсний стандартуудыг олон улсын болон бусад орны дэвшилтэт технологид нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

6.4.4. зам, тээврийн салбарт мөрдөж буй олон улсын болон бүс нутгийн стандартуудын суурь стандартуудад өөрчлөлт орсон бол түүнд нийцүүлэн дахин боловсруулан мөрдүүлэх;

6.4.5. аж ахуй нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр боловсруулах стандартын төслийг дэмжих, хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх ;

6.5. Сургалт, сурталчилгаа, хэрэгжилтийг зохин байгуулах


6.5.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах, идэвх, оролцоог нэмэгдүүлж ажиллах;

6.5.2. стандарт боловсруулах, орчуулах, хянах зэргээр оролцож буй мэргэжилтэнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх, зөвлөмж авах зорилгоор гадны мэргэжлийн байгууллагуудаас экспертүүдийг урих;

6.5.3. холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагаас санал авч хэлэлцүүлэх;

6.5.4. салбаруудын стандартын мөрдөлт, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх;

6.5.5. Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд зам, тээврийн салбарт мөрдүүлэхэд тохирохоор сонгон боловсруулж Үндэсний болгон батлуулсан шинэ



дэвшилтэт стандартуудыг сургалчилах талаар сургалт семинар зохион байгуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх үйл ажиллагааг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 7.1.1. улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- 7.1.2. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;
- 7.1.3. Олон улсын зээл, тусламж, төслийн санхүүжилт;
- 7.1.4. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- 7.1.5. бусад эх үүсвэр;

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааны санхүүжилтийн хуваарь:

- 7.2.1 2013 онд 262 140 000.00 сая.төгрөг
- 7.2.2 2014 онд 700 000 000.00 сая.төгрөг
- 7.2.3 2015 онд 400 000 000.00 сая.төгрөг
- 7.2.4 2016 онд 100 000 000.00 сая.төгрөг

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Орчин үеийн эдийн засаг дахь өөрчлөлтүүд, нийгэм эдийн засгийн хөгжлийн үйл явц үндсэндээ дэд бүтэц түүний дотор зам, тээврийн идэвхжил томоохон байр сууриар тодорхойлогдож, нийгмийн хөгжлийн өөрчлөлтөөр илэрхийлэгдэнэ. Олон улсын түвшинд нийцсэн нэгдсэн тээврийн үйлчилгээ нь боловсронгуй стандарт техникийн баримт бичгийг түгээн, дэлгэрүүлж, мөрдүүлж, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэнээр тодорхойлогдоно.

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

8.1.1. зам, тээврийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмж, байгууллагуудын чадавхи дээшилж салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна;

8.1.2. зам, тээврийн салбарт шинжлэх ухаан техникийн дэвшилтэт технологи нэвтэрсэн байх, цаашид эрчимтэй нэвтрэх боломж бүрдэнэ;

8.1.3. зам, тээврийн салбарт олон улсын шинэ дэвшилтэт стандарт нэвтэрсэн байна;



145

8.1.4. хөтөлбөрийг хэрэгжүүлснээр салбарын хүрээнд мөрдөх олон улсын жишигт нийцсэн багц стандарттай болно;

8.1.5. эдгээр үр дүнд хүрсэнээр зам, тээврийн салбарын стандартууд нь орчин үеийн эрэлт, хэрэгцээг хангахуйц, олон улсын түвшинд хүрсэн үндэсний нэгдсэн тээврийн стандартын үр ашигтай тогтолцоо бүрдэнэ;

8.1.6. авто тээврийн салбарт хөтөлбөр хэрэгжсэнээр нийт стандартын 90 орчим хувь нь олон улсын жишигт хүрсэн байна.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлдэхдээ дараах зарчмыг баримтална:

8.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй бусад холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрүүдтэй нягт уялдсан байх;

8.2.2. салбарыг хөгжүүлэх арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэрэглэгчдийн хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулж хэрэгжүүлэх тэдгээрийн эрх тэгш оролцоог хангаж, уялдаа холбоог бэхжүүлэх;


8.2.2. үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах;

8.2.3. салбарыг хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон улсад мөрдөгдөж бодлого, чиглэлтэй нийцсэн байх бөгөөд тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах.


8.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

8.3.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх бие даасан зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцаж, жил бүр яамны ШУТЗ-д ажлаа тайлагнах

8.3.2. ЗТЯ, СХЗГ, Улсын болон орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагууд, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн төрийн бус байгууллагууд, инженер, техникийн ажилчдаас тавьсан хяналт, хөтөлбөртэй холбоотой дүгнэлт, үнэлгээ, санал, зөвлөмж нь хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтын нэг хэсэг болно.




Зам, тээврийн сайдын 2013 оны
04 дугаар сарын 25 өдрийн 85 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ДУНД ХУГАЦААНЫ
ХӨТӨЛБӨР(2013-2016 ОН)-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах хөрөнгийн тооцоо /сая төг/	Хөрөнгийн эх үүсвэр
1 дүгээр зорилт: Олон улсын болон бүс нутгийн стандартыг Монголд нутагшуулах						
1	Шинээр нэвтрүүлэх стандартын тогтолцооны талаар байгаль цаг уурын нөхцлөөр ижил төстэй хөгжингүй орны туршлага дээр тулгуурлан судалж, зөвлөмж гаргах	СБТГ	ЗТЯ-ны бусад газрууд, СХЗГ	2013 оны 2-р улирал	15,0	Улсын төсөв
2	Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд мөрдөхөд тохиромжтой стандартуудыг сонгож, тэдгээрийг эзэмшиж буй байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулах	СБТГ	ЗТЯ-ны бусад газрууд	2013 оны 2-р улирал	-	-
3	Шинэ дэвшилтэт стандартуудыг Монгол орны үндэсний стандарт болгон нутагшуулахад шаардагдах хөрөнгийг тооцон, эх үүсвэрийг тодорхойлох	СБТГ	ЗТЯ-ны бусад газрууд	2013 оны 3-р улирал	-	-
4	Зам, тээврийн салбарт нэн түрүүн нэвтрүүлэх шаардлагатай ISO-ийн стандарт, Европын холбоо, бусад дэвшилтэт стандартын жагсаалт гаргаж батлуулах	АТБХЗГ АЗБХЗГ ТЗУЗБХЗГ ИНБХХ	СБТГ	2013 оны 1-р улирал	-	-
5	Нэн түрүүн нэвтрүүлэх шаардлагатай ISO-ийн стандарт, Европын холбоо, бусад дэвшилтэт стандартуудыг худалдан авах	АТБХЗГ АЗБХЗГ ТЗУЗБХЗГ ИНБХХ	СБТГ	2013-2016 он	220,0	Улсын төсөв



6	Салбарт шаардлагатай стандартуудын төслийг боловсруулах	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	Төрийн болон төрийн бус байгууллага, ААНБ	2013-2016 он	300,0	Улсын төсөв
7	Эх хэлнээ хөрвүүлэн боловсруулсан стандартуудад холбогдох санал авч, хянан боловсруулж, зохих шатны хурлуудаар хэлэлцүүлэн дэмжүүлж Монгол Улсын Үндэсний стандартаар батлуулах	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	СБТГ	2013-2016 он	150,0	Улсын төсөв
8	Олон улсын стандартуудыг Зам, тээврийн салбарт нэвтрүүлэхтэй холбогдуулан шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай хууль тогтоомж, дүрэм, журамд санал оруулах	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	СБТГ	2013-2016 он	-	-
9	MNS болсон олон улсын стандартуудыг Монгол улсын зам, тээврийн салбарт мөрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	СБТГ	2013-2016 он	50,0	Улсын төсөв
2 дугаар зорилт: Үндэсний стандартуудыг шинэчлэн боловсруулах						
10	Монгол Улсын зам, тээврийн салбарт мөрдөж буй олон улсын болон үндэсний нийт стандартуудад шинжлэх ухаан, техникийн үзлэг хийж дүгнэлт гаргах	СБТГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2013 оны 1-р улирал	17,14	Улсын төсөв
11	Үзлэгийн дүгнэлтийг үндэслэн шинэчлэх болон хүчингүй болгох стандартуудын жагсаалт гарган батлуулан мөрдөх	СБТГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2013 оны 3-р улирал	-	-
12	Үзлэгийн дүгнэлтийг үндэслэн цаашид үргэлжлүүлэн мөрдөх шаардлагатай үндэсний стандартуудыг олон улсын болон бусад орны дэвшилтэт технологид нийцүүлэн шинэчлэн боловсруулах;	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	СБТГ	2013-2016 он		

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
 С.Ид. Төрш, нарийн бичгийн даргын
 2013 оны 85 дугаар тушаал

3 дугаар зорилт: Сургалт, сурталчилгаа, хэрэгжилтийг зохин байгуулах

13	Стандарт боловсруулах, орчуулах, хянах зэргээр оролцож буй мэргэжилтэнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	СБТГ ТЗУГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2013-2016 он	50,0	Улсын төсөв
14	Стандартыг оновчтой нэвтрүүлсэн гадаад орны туршлага судлах	СБТГ ТЗУГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2014-2015 он	400,0	Улсын төсөв
15	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоодын болон гадаадын мэргэжлийн шинжээч экспертүүдийг урьж зөвлөмж авах	СБТГ	СХЗГ ТББ	2014 он	100,0	Улсын төсөв
16	Стандартын тогтолцоог нэвтрүүлэх талаар иргэд, олон нийт, аж ахуй эрхлэгчдэд заавар зөвлөгөө өгч, үе шаттай сурталчилгаа явуулж, гарын авлага, сурталчилгааны материалыг бэлтгэн тараах	ТЗУГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2013-2016 он	150,0	Улсын төсөв
17	Стандартын тогтолцоог нэвтрүүлэхэд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, мөрдүүлэх талаар Зам, тээврийн яамны шийдвэр гаргуулах	СБТГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	2013 оны 2-р улирал	-	-
18	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцад жил бүр хөндлөнгийн мониторинг хийлгэж, дүгнэлт гаргуулан сургалт зохион байгуулах, холбогдох Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, техникийн зөвлөлд танилцуулах	СБТГ	Бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрууд	Жил тутам	10,0	Улсын төсөв

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

Галд, Төрийн нарийн бичгийн даргын
2013 оны 85 дугаар тушаал